

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2023 он

Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 70342580

Аудитын менежер:

Утас: 70342716

Ахлах аудитор:

Утас: 70342716

Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn

Ж.Энхцоодол

Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Г.Намчинсүрэн

Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу,

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	8

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 236
танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Х.ХАЛИУНБАТ ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бугат сумын ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 25,751.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,826.0 мянган төгрөгөөр давж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20.2.3, 20.2.6, 20.2.9, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.6, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2, 71.3 заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүхэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд бэлтгэсэн 15,000.0 мянган төгрөгийн өвсийг бүртгэл тайлант тусгаагүй;
- Шатахуун зарцуулахдаа 100 км-т баримтлах нормыг баримтлаагүй 281.0 мянган төгрөгийг илүү тооцон олгосон;
- Урьдчилан олгосон 500.0 мянган төгрөгийг суутган тооцоолоогүй, бүртгэл тайланд авлагаар бүртгээгүй;
- НӨАТ-ын баримтгүй нийт 5,980.0 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн;
- Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 3,990.8 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

000020525

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Бугат сумын ЗДТГ нь өөрийн байрны гадаад, дотоод бүрэн засвар хийсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 50.5 хувиар өссөн байна.

Бусад мэдээлэл

Тус байгууллага нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 96 хувиар үнэлжээ.

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

	Үзүүлэлт	2022.12.31	/Төгрөгөөр/ 2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	82,842,496.2	76,277,459.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,345,226,169.2	2,282,115,782.6
	Нийт хөрөнгийн дүн	1,428,068,665.4	2,358,393,242.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	2,205,734.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,428,068,665.4	2,356,187,508.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,428,068,665.4	2,358,393,242.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	619,221,652.0	1,258,097,105.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	728,384,620.3	1,328,247,018.3
	Үйл ажиллагааны үр дүн	(109,162,968.3)	(70,149,913.3)
	Үйл ажиллагааны бус үр дүн	2,343,233.1	2,177,885.9
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(111,506,201.3)	(72,327,799.2)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,428,839,720.3
	Тайлант оны үр дүн	406,726,278.0	928,118,842.8
	Эцсийн үлдэгдэл	1,428,068,665.4	2,356,187,508.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	619,221,652.0	1,258,097,105.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	594,386,552.0	1,247,303,105.0
	Үйл ажиллагааны ЦМГ	24,835,100.0	10,794,000.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(24,835,100.0)	(10,794,000.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	694,190,600.00	615,275,575.45
	Урсгал зардал	694,190,600.00	615,275,575.45
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	694,190,600.00	627,777,600.0
	Улсын төсвөөс санхүүжих	645,286,100.00	620,951,600.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	48,904,500.00	6,826,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 602,351.8 төгрөгийн зөрчил¹ илэрснээс 3,861.0 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 592,510.1 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 5,980.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 25,751.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,826.1 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Шатахуун зарцуулахдаа 100 км баримтлах норм, нормативыг баримтлаагүй 281.0 мянган төгрөгийн шатахууныг илүү тооцон олгож Төсвийн тухай хуулийн 5.1.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7-д заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Тайлан хугацаанд 1 албан хаагчаас 500.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалинг суутгаагүй, бүртгэл тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д, 26 дугаар зүйлийн 26.1, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3. Хүндэтгэлийн арга хэмжээнд зориулан 1,080.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4. Санхүүчдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд 500.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4, Засгийн газрын тогтоол 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.6-д заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5. Булган аймгийн Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумдын 100 жилийн ойд зориулан 1,500.0 мянган төгрөгийн хандив өгсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4, Төсвийн тухай хуулийн 25.10-д заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29 удаагийн орлогын нийт 562,725.3 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 3,990.8 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.5, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1-2.1.6, 5.2 дахь заалттай нийцээгүй,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант онд бэлтгэсэн 15,000.0 мянган төгрөгийн тэжээлийн будааг бүртгэл тайланд тусгаагүй, мөн жилийн эцсийн тооллогоор тоологдоогүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.4, 20.2.6, 20.2.9, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.2, 71.3-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин нийт 10,794.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ахмадын баяр, аварга малчинд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд зориулан худалдан авсан хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.6. санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.6-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

[illegible]

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зардлыг илүү тооцон олгосон.	1	281.0	1	281.0								
Цалингийн урьдчилгааг суутгаагүй	1	500.0	1	500.0								
Тайлант онд бэлтгэсэн өвсийг бүртгэл тайланд тусгаагүй	1	15,000.0			1	15,000.0						
НӨАТ-ын баримтгүй худалдан авалт хийсэн	1	5,980.0					1	5,980.0				
Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох журмыг баримтлаагүй зориулалт бус зарцуулсан.	1	3,990.8			1	3,990.8						
Дүн	5	25,751.8	2	781.0	2	18,990.8	1	5,980.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны цахим хуудсанд нийт 29 удаагийн нийт 562,725.3 мянган төгрөгийн таван сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй.	1	562,725.30			1	562,725.3				
Дүн	1	562725.3			1	562,725.3				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/										
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин нийт 10,794.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй.	1	10,794.0			1	10,794.0				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин бэлэг дурсгалын зүйл, хүнс худалдан авсан	1	1,081.0	1	1,080.0						

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин санхүүчдийн баяр тэмдэглэсэн	1	500.0	1	500.0				
Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль зөрчин хандив олгосон	1	1,500.0	1	1500.0				
Дүн	4	13,875.0	3	3,080.0	1	10,794.0	-	-
Нийт дүн	5	576,600	3	3,080	2	573,519.3	-	-